

ОРЧУУЛГА / TRANSLATION <https://doi.org/10.5564/spej.v38i1.3173>**Г.В. Лейбниц: Мэргэн ухаанд суралцахуй****Будрагчаагийн Даш-Ёндон ***

*Доктор (Sc.D), профессор
Шинжлэх Ухааны Академийн Философийн хүрээлэн,
Улаанбаатар, Монгол Улс
dashyondonbudragchaa@gmail.com*

Хураангуй:

Зохиогч (Г.В.Лейбниц)-ийн өөрийнх нь тодорхойлсон ёс зүйн зарим нэр томъёог өнөөгийн цаг дор ихээхэн сонирхолтой хэмээн үзэж ийнхүү хөрвүүлжээ. Тухайлбал, зохиогч (Г.В.Лейбниц) “**шударга ёс** (справедливость) - энэ бол мэргэн ухаантны ариун сэтгэл, эсхүл мэргэн ухаанд нийцсэн ариун сэтгэл хэмээсэн байна. **Ариун сэтгэл** (милосердие) гэдэг бол бүх талын сайн сайхныг хүсэхүй болой, **мэргэн ухаан** (мудрость) бол дээд аз жаргалын тухай эрдэм ухаан юм, **аз жаргал** (счастье) хэмээх нь удаан хугацааны баяр баясгалантай төрх байдал, **баяр баясгалан** (радость) нь төгс сайхан мэдрэмж, **төгс сайхан** (совершенство) нь бодит байдлын үе шат юм” гэсэн талаар зохиогчийн өөрийн хийсэн тайлбараар хөрвүүлгийг хийсэн байна

Түлхүүр үгс: *мэргэн ухаан, аз жаргал, баяр баясгалан, төгс сайхан*

Gottfried Wilhelm Leibniz: Learning the wisdom**Dash-Yondon Budragchaa***

*Doctor (Sc.D), professor
Institute of Philosophy, Mongolian Academy of Sciences
Ulaanbaatar, Mongolia
dashyondonbudragchaa@gmail.com*

Abstract:

The translator of the short paper translated some of the ethical terms defined by the author (W.W. Lederstein) as very interesting at the time. For example, the author G.W. Leibniz said that “justice” is a sacred spirit of wisdom or the sacred spirit corresponding to wisdom. Mercy is the pursuit of all good, wisdom is the knowledge of supreme joy, joy is the permanent joy, and joy is the perfect beauty. “Feeling and perfect beauty (perfection) are the stages of reality.

Keywords: *wisdom, happiness, and joy, perfection*

*Орч. Б.Даш-Ёндон



© The Author(s) 2023

<https://creativecommons.org/licenses/by/4.0/><https://orcid.org/0009-0002-4306-8841>

Received: 18 August 2023

Accepted: 25 September 2023

I. Оршил

Г.В.Лейбниц: «Хүмүүсийн ухаан бол доторх нь бүгд сугаран унах хүртэл сэгсэрцгээдэг уут лугаа төстэй» гэж Мариот бичжээ. Тэгвэл би үүн дээр нь нэмж: Хүмүүсийн ухаан бол сэтгэх явцад хамгийн жижиг хэсгүүд нүхээр нь гадагшилж дуусах хүртэл сэгсэрцгээдэг шигшүүр лүгээ илүү төстэй гэж хэлмээр байна» (Лейбниц 1984) хэмээжээ.

Тэрээр бас ёс зүйн зарим нэр томъёог өөрийнхөөрөө тодорхойлсон нь ч ихээхэн сонирхолтой юм. Жишээ нь, “**шударга ёс** (справедливость) - энэ бол мэргэн ухаантны ариун сэтгэл, эсхүл мэргэн ухаанд нийцсэн ариун сэтгэл юм. **Ариун сэтгэл** (милосердие) гэдэг бол бүх талын сайн сайхныг хүсэхүй болой, **мэргэн ухаан** (мудрость) бол дээд аз жаргалын тухай эрдэм ухаан юм, **аз жаргал** (счастье) хэмээх нь удаан хугацааны баяр баясгалантай төрх байдал, **баяр баясгалан** (радость) нь төгс сайхан мэдрэмж, **төгс сайхан** (совершенство) нь бодит байдлын үе шат юм” (Лейбниц 1984) гэсэн байна.

Улмаар Г.А.Лейбниц “...философичид бусад хүмүүсийн харж буй тэр л зүйлийг хардаг, чингэхдээ тэд бусад хүмүүсийн хайхардаггүй тэр зүйлд нь анхаарлаа хандуулдаг” (Лейбниц 1984), “Философич хүн ард олныг захирагсдыг, ерөөсөө бүх л гарамгай сайчуудыг итгүүлэн үнэмшүүлэхэд бүх хүч чармайлтаа гаргах ёстой” (Лейбниц 1984) гэжээ.

Бидний ишлэн буй эдгээр илэрхийлэл нь ихэд сонин санагдсан тул түүний “Мэргэн ухаанд суралцахуй” гэдэг эсээг нь орчуулбай.

Эл эсээ нь, Зөвлөлтийн эрдэмтэн Г.Г.Майровын бичсэнээр бол, Лейбниц олон нийтэд зориулан хэвлүүлэхэд бус, зөвхөн өөртөө анхааруулсан урьдчилсан тэмдэглэлийн шинжтэй, жинхэнэ мэргэн ухаан гэж юу вэ, түүнийг эзэмдэнэ гэдэг нь юу вэ хэмээн боддогоо илэрхийлсэн ноорог тэмдэглэл аж (Лейбниц 1984).

Гэвч энэ ноорог тэмдэглэлийг зөвхөн Лейбницийн хувийн хэрэг гэж бодвол бас ч явцуурсан санаа болж магадгүй тул философичийн бодол нийтэд хүртээлтэй гэх үүднээс хэн нэгэнд тус болог гэж орчууллаа. Энэ эсээд танин мэдэхүйн онолын болон аргачлалын зарим чухал асуудал хөндөгдсөн байна.

Германы их философич Г.В.Лейбниц (1646-1716) математикч, физикч, хуульч байсан бөгөөд философиор Платон, Аристотель, Гоббс, Декартын бүтээлүүдийг нарийвчлан судалжээ. Тэрээр «түгээмэл шинжлэх ухаан»-ыг бий болгох санааг насан туршдаа баримталсан ажээ.

II. Судалгааны арга зүй

Г.В.Лейбниц “Мэргэн ухаанд суралцахуй” хэмээх бэсрэг бүтээлдээ: **Мэргэн ухаан**-бол бүхий л шинжлэх ухааны зарчмуудыг төгс мэдэж, тэдгээрийг хэрэглэх ур чадвар юм. Зайлшгүй тохиолд бүхий л дүгнэлтийг өөрсдөөс нь гарган авч, дараа нь энэ дүгнэлтүүдээрээ дасгал хийж зарим үед хэрэглэхэд хангалттай бүхий л суурь үнэнийг би зарчмууд хэмээн нэрлэж байна. Ер нь л, зан суртахууныг хянах гэсэн оюун санааны эрмэлзэлд удирдлага болдог, газар сайгүй (чи варваруудын дунд байсан ч) оршиж, эцсийн дүндээ таатай амьдралд хүрэхийн тулд эрүүл мэндээ

сахих, чамд гарцаагүй хэрэгтэй бүх юманд төгөлдөршихөд эрхэмлэгддэг тэр бүх зүйлийг би зарчмууд гэж нэрлэв. Эдгээр зарчмыг нөхцөл байдалд хэрэглэх ур чадвар нь сайн бодох юм уу шүүн тунгаах ур чадварыг, шинэ үнэнийг нээх ур чадварыг, эцэст нь, нэгэнт илэрхий байгаа зүйлийг цагийг нь олж, хэрэгтэй үед нь эргэн санах ур чадварыг багтаан агуулж байдаг хэмээн тэмдэглэсэн нь бий.

III. Хэлэлцүүлэг

Сайтар шүүн тунгаах ур чадвар дараахь хэм зохицолд оршино:

1. Эргэлзэх² ямар нэгэн шалтаг гаргах ямар ч юм олох боломжгүй тийм илэрхий мэдээжийн зүйлийг л үнэн гэж ямагт хүлээн зөвшөөрөх хэрэгтэй. Чухам ийм учраас тийм эрэл хайгуулын эхэнд, чи эсрэг талыг нь баримтлах сонирхолтой буйгаа төсөөлөх нь нэн чухал, учир нь, тийм арга барил үндэслэлийн буруу зөрүүг илрүүлэх ямар нэгэн буурьтай зүйлийг олоход чамайг чиглүүлсэн билээ, юу гэвэл, дасчихсан охор бодлоос зайлсхийх хэрэгтэй, юманд өөрт нь байхгүй зүйлийг байлгах гэх шаардлагагүй буюу. Гэхдээ хэзээ ч өөрийнхөөр зүгээд байх хэрэггүй.

2. Хэрэв тийм итгэл үнэмшилд хүрэх боломжгүй бол танихуйн томоохон үр дүнд хүрэх магадлалд л найдахаас өөр аргагүй болно. Гэхдээ магадтайгайн үе шатыг ялгах хэрэгтэй, улмаар зөвхөн магадтайн зарчмаас бидний гарган авч буй бүх юманд түүний эх сурвалжийн төгс бус байдлын улбаа байсаар байдгийг анхаарах хэрэгтэй, ялангуяа дүгнэлтэд хүрэхийн тулд хэд хэдэн магадлалыг авч үзэх хэрэгтэй болсон шүү дээ, учир нь гэвээс, дүгнэлт болбоос түүний өөрийн нь үндэс болж буй ямар ч магадлалаас бүр бага танигдсан байдаг.³

3. Нэг үнэнээс нөгөөг нь гаргахын тулд тэдгээрийн ямар нэгэн салшгүй гинжин холбоог хадгалан сахих хэрэгтэй. Учир нь, хэрэв гинжний шижим бүр нь сайн материалаас бүрдсэн гэдэгт, бас гинжний шижим бүр нь хажуугийн хоёр шижимтэйгээ баг холбогдсон гэдэгт итгэхгүй байгаа бол, хэрэв энэ шижмийн өмнө нь юу байгаа, ард нь юу байгаа нь тодорхой бус бол гинж ачааг дааж тэснэ гэдэгт итгэлтэй байх аргагүй, яг үүнчлэн хэрэв оюун дүгнэлт сайнгүй материалтай, өөрөөр хэлбэл ямар нэгэн эргэлзээтэй зүйлийг өөртөө агуулж байгаа бол, хэрэв оюун дүгнэлтийн хэлбэр нь ямар ч хоосон зай үлдээгээгүй үнэнүүдийн салшгүй холбоо болж чадаагүй бол уг оюун дүгнэлт үнэн зөв гэдэгт итгэлтэй байх аргагүй.⁴ Жишээ нь, А бол В мөн, В бол С мөн, С бол D мөн, ингэхлээр А бол D мөн гэдэг шиг. Иймэрхүү гинжин хэлхээ нь үндэслэгээнүүдэд байгаагаас илүү зүйлийг дүгнэлтэд хэзээ ч оруулж болохгүй гэдгийг бидэнд сануулж байна.

IV. Судалгааны үр дүн

Нээлт хийх (шинийг олох) ур чадвар дараахь хэм зохицолтой байна.

² Энэ хэм хэмжээ Декартын “эргэлзээний зарчим”-тай адил байна. Гэхдээ Лейбниц дараагийн бүтээлүүддээ энэ зарчмыг ашиг тус багатай гэж үзжээ. (орос хэвлэлийн тайлбар, Б.Д.)

³ Г.Лейбниц эртний энэ бүтээлдээ ч гэсэн мэдлэгийн магадлалын асуудалд Декартаас илүү их анхаарчээ. «Новые опыты о человеческом разуме...» Соч.т.2.с.21-98 (орос хэвлэлийн тайлбар)

⁴ Энэ хэм зохицол нь шүүн тунгаахуй тууштай байх шаардлагыг илэрхийлдэг Декартын аргын 3 дахь дүрэмд ойролцоо байна (орос хэвлэлийн тайлбар)

1. Ямар нэгэн юмыг танихын тулд түүнийхээ бүхий л реквизит⁵, өөрөөр хэлбэл, энэ юмыг бусад бүхнээс нь ялгахад хангалттай бүхнийг авч үзэх хэрэгтэй. Энэ нь “тодорхойлолт”, “уг чанар”, “харилцан холбогдох шинж” хэмээн нэрлэгддэг тэр зүйл юм.

2. Нэг юмыг нөгөөгөөс нь ялгах аргыг нэгэнт олсон бол нөхцөл нэг бүрийг, эсхүл энэ аргад реквизит - үүдийг, бас тэрчлэн эдгээр реквизитүүдээс реквизит нэг бүрт нь нэгдүгээр дүрмийг хэрэглэх хэрэгтэй. Энэ нь үнэлгээ задлан шинжилгээ юм уу эсхүл бэрхшээлийг хэд хэдэн хэсэгт хуваахуй хэмээн миний нэрлэдэг тэр зүйл. Учир нь, бэрхшээлүүдийг хэд хэдэн хэсэгт хуваах хэрэгтэй гэж өмнө нь хэлцгээдэг байсан боловч яаж хийх ур чадварыг хараахан зааж зааварлаагүй, тодруулах гэхээсээ бүдгэрүүлдэг хуваалтууд байдаг гэдгийг анхаарахгүй байв. ⁶

3. Шинжилгээ төгсгөлдөө хүрсэн үед, өөрөөр хэлбэл, байгаагаараа танигдсан, реквизитүүд байхгүй, өөрийг нь ойлгоход өөрөөс нь гадна өөр юу ч хэрэггүй байдаг зарим юмсыг авч үзэхэд оролцдог реквизитүүдийг судалж буй үед тухайн юмыг **таньсан төгөлдөр мэдлэгт** хүрнэ.

4. Юм ийм бололцоо олгож буй бол танихуй оюун ухаанд бүхэлдээ шууд байж байхуйцаар юмыг төгс танин мэдэхийг эрмэлзэх хэрэгтэй; харин энэ нь нэг бус удаагийн давтан шинжилгээгээр олдоно, эл давтан шинжилгээг, бид юмыг бүхэлд нь оюун ухааныхаа хараанд авлаа хэмээн санагдах хүртлээ, үргэлжлүүлэх хэрэгтэй. Ийм үр дүнд хүрэхийн тулд шинжилгээг давтахдаа тодорхой, тууштай дэс дарааллыг баримтлах нь зүйтэй.

5. Хэрэв судалж байгаа юманд чинь тайлбар өгвөл зохих юу ч үлдээгүй бол, бас хэрэв **эртнээс урьдчилан хэлж** болох байсан тийм зүйл тус юманд үлдээгүй бол энэ нь төгс мэдлэгийн шинж болно. Юмсыг эцэст нь хүртэл шинжлэх нь маш хэцүү, гэхдээ шаардлагатай байгаа үнэний шинжилгээг дуусгах нь тийм ч хэцүү биш. Яагаад гэвэл, үнэний нотолгоо нь олдсон бол үнэний шинжилгээ дууслаа гэсэн үг, улмаар, өгүүлбэрийн нотолгоог олохын тулд субъект юм уу предикатын шинжилгээг дуусгах гэх нь заавал алба биш. Юмыг шинжлэх эхлэл нь шинжилгээ хийхэд, эсхүл уг юмсаа хамаарах үнэнийг төгс танин мэдэхэд хангалттай байдаг нь олонтоо.⁷

6. Судалгааг ямагт хөнгөн юмсаас эхлэх хэрэгтэй, энэ нь илүү ерөнхий, илүү энгийн юмс гэсэн үг, өөрөөр хэлбэл, туршилт хийхэд амар, энэ туршилтаасаа үндэснүүдийг нь олоход хялбар, ухаандаа, тоо, шулуун хөдөлгөөн гэх мэтээс эхлэх хэрэгтэй.

⁵ Лейбниц **реквизит** гэдэг нэр томъёогоор, гол төлөв, түүний хэлдэг бодит тодорхойлолтод зайлшгүй агаад хангалттай байх ойлголтын шинж байдлыг тэмдэглэдэг. Түүний хамт реквизитүүд гэдэг нь задлан шинжилгээг төгсгөлд нь хүргэдэг элементүүд юм. Реквизитүүд задлагдашгүй, ингэхлээр, тодорхойлогдошгүй ойлголтууд гэж байхгүй. Бодомжууд дахь ойлголтуудад реквизитүүд предикат болж үйлдчилдэг гэнэ (орос хэвлэлийн тайлбар)

⁶ Энд Декарт агаад декартуудыг хэлж байна. Декарт өөрийнхөө аргад нийцүүлэн хүнд асуудлуудыг илүү хялбар болгох ёстой гэж үздэг байсан авч ийм шинжилгээний цэгцтэй онолыг бий болгоогүй билээ. (орос хэвлэлийн тайлбар)

⁷ Лейбниц энэ хэсгийгээ хожим нэмж оруулжээ. (орос хэвлэлийн тайлбар)

* Тайлбар тольд: «Дихотом» - бүхлийг хоёр хэсэгт хувааж, дараа нь хэсэг бүрээ дахиад хоёр хуваах гэх мэтээр урагшлах, ангилан ялгаж буй үзэгдлүүдээ хосоор нь сөргүүлэн тавьж ялган салгахад үндэслэсэн задаргаа гэжээ (мон.орч)

7. Илүү хөнгөн юмсаас илүү хэцүү юмс руу өгсөн дээшлэх дэглэмийг ямагт баримталбал зохино, чингэхдээ бидний шүүн тунгаахуй нь байгалийг өөрийг нь замчин, батлан илэрхийлэгчээ болгосон тийм дэвшин урагшлах хөдөлгөөнийг олохыг эрмэлзэх хэрэгтэй.

8. Бид бүхий л хуваарилалт, тооцоондоо юу ч гээхгүй байхыг хичээх хэрэгтэй. Харин ингэхэд эсрэг гишүүн бүхий дихотом* маш сайн тусална.

9. Салангид тусдаах янз бүрийн юмсыг хэд хэдэн удаа шинжилсний үр дүн нь ерийн санаанд ойролцоо, энгийн жагсаалт болж гарна.

10. Энгийн санаануудын ийм жагсаалт гаргасан бол бүх аргачлал-ийг дахин шинжилж юмсын гарал үүслийг тайлбарлах хэрэгтэй, чингэхдээ ямар нэгэн төгс дэг, ямар нэгэн хэлхээ холбоо юм уу, бүрэн төгс синтезийг үндэс болгон авах нь зүйтэй. Энэ бол бидний оюун санааг одоо байгаа тийм төрх байдалтай болгох тэрхүү бүх зүйл юм.

Бид мэдэж байгаа юмаа цагийг нь олж, хэрэгтэй үед нь хэрэглэх ур чадвар дараахь дүрмүүдэд оршино.

(1) **Тайван байдлаа ямагт хадгалж сурах хэрэгтэй**, энэ нь будилж сандарсан үед, ер нь ямар ч нөхцөл байдалд сэтгэн тунгаах чадвараа алдахгүй байх ёстой гэсэн үг, гайхаш алдрах үед өрөөндөө сууж байх нь (тайван байх нь, Б.Д) дээр. Ийм учраас ямар ч нөхцөлд барьц алдахгүй байх хэрэгтэй, захын юманд орооцолдохгүйн тулд нэлээд болгоомжтой байвал зохино, тэхдээ засаршгүй алдаа гаргахгүй байхыг хичээх. Зөвхөн дэвэргэн бодохуй, бас дээр нь тоглоом шоглоом, хуран зөвлөхүй, харилцан яриа, бие бялдрын дасгал, яриа наргианыг нэмж бод.

(2) **Тооцоолон анхаарахад суралцах хэрэгтэй**. Юу гэвэл, нэг төрөл зүйлийн бүх дүрс, ямар нэгэн арга хэрэгслийн аятай аягүй байдал, ямар нэгэн зорилгод хүргэх бололцоотой эсэх зэрэг бүхий л тохиолдлыг эхнээсээ анхааран харгалзах хэрэгтэй.

(3) **Ялгаж салгахуйд суралцах нь чухал**: өвөр хоорондоо адил төсөөтэй хоёр юм уу хэд хэдэн юмсыг мэдсэн бол тэдгээрийнхээ ялгааг гаргахад тэр дор нь анхаарах хэрэгтэй.

(4) **Адил төстэйг олоход суралцах хэрэгтэй**: нэн ялгаатай хоёр юм уу хэд хэдэн юмсыг мэдсэн бол тэдгээрийнхээ ижил төсөөтэй байдлыг шалавхан олж мэдэх нь чухал.

(5) Тухайн юманд маш төстэй, эсхүл түүнээс маш ялгаатайг нь шуудхан ялган салгаж чаддаг байх хэрэгтэй. Жишээ нь, миний хэлсэн зарим нэг ерөнхий хэм зохицлыг хэн нэг нь няцаах үед би ямар нэгэн жишээг түүнд нь сөргүүлэн тавивал сайн. Улмаар, өөр хэн нэг нь миний эсрэг ямар нэг хэм зохицол сөргүүлэн тавивал би түүнд ямар нэгэн жишээг шууд л сөргүүлэн тавивал зүгээр. Надад ямар нэгэн түүх ярьцгааж буй үед би тэр дор нь ижил төстэйг нь мэдээлбэл сайн.

(6) Субъект, предикат хоёр дахь бидэнд мэдэгдэхгүй байгаа жам ёсны хэлхээ холбоог агуулсан үнэн юм уу мэдлэг лүгээ бид тулгарсан бол (ийм зүйл бодит юманд ч, туршилтын аргаар олсон үнэнд ч тохиолддог, жишээ нь, эмийн ургамлын өвөрмөц шинжийн тухай, байгалийн, иргэний, сүм хийдийн түүхийн тухай, газар зүйн тухай, зан үйл, хууль цааз, дэг жаягийн тухай, хэл ярианы тухай яригдаж

буй үед бол) тэдгээрийг оюун санаандаа тогтоож авахын тулд онцгой зохиомол арга хэрэглэхээс өөр гарцгүй. Тэдгээрийг ой ухаандаа тогтоон барихад хошин шог шүлэг зохиол, заримдаа уран зургаас илүү сайн тохирох юм үгүй, бас тэдгээрийг тайлбарлахад байгалийн юмсыг хэлэлцэхэд гардаг шигээр зохион бодсон таамаглал ч хэрэгтэй хэмээн би бодмуу. Жишээ нь, хэл ярианы хувьд гэхэд л үгийн гарвал зүйг зөв, буруу ашигладаг, эсхүл *Regula mundi*⁸ гэхэд л хэрэв энэ хуулийг түүхэн дэх ирээдүй таамаглалын тодорхой дэг жаяг хэмээн үзэх нь буй.

(7) Эцэст нь, илүү ашиг тустай мэдлэгүүдийн дээсэлсэн жагсаалт гаргаж, түүнээ данслах юм уу цагаан толгойн хэлхээсэнд оруулбал зүгээр. Төгсгөлд гэвэл, үүнээ эш үндэс болгож хамгийн зайлшгүй, хамгийн өргөн дэлгэрсэн бүхнийг оруулсан **өврийн дэвтэр** зохиох хэрэгтэй.

Ашигласан материал

- Лейбниц, Г.В. 1984. *Сочинения в 4-х томах т.1 (Философское наследие)*. авт. вступит, статьи и примеч. В. В. Соколов ед. и сост. Москва: Мысль.
- *Сочинения в 4-х томах т.1 (Философское наследие)*. авт. вступит, статьи и примеч. В.В.Соколов и сост. Москва.

⁸ *Regula mundi* - лат. Ертөнцийн хууль